

## **ЗАЛУУ СУДЛААЧДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ**

Монголын шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан Олон Улс Судлалын Хүрээлэн 2008 оны 12 дугаар сарын 3-ны өдөр эрдэм шинжилгээний залуу ажилтнуудын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, илтгэл шалгаруулав.

Хурлыг илтгэл шалгаруулах комиссын дарга доктор К.Дэмбэрэл нээж, залуучуудад амжилт хүсэв.

Хуралд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний залуу ажилтнууд өөрсдийн судалж буй сэдвийн дагуу Хойд Солонгосын хүний эрхийн асуудал, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль, Үндэсний аюулгүй байдал ба шашны асуудал, Номадизм ба соёлын хэлбэр, Бүс нутаг судлалын асуудал, Японы улс төрийн тогтолцоо болон Монгол-Орос, Монгол-Герман, Монгол-Турк, Монгол-Канадын харилцаа, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг асуудлаар нийт 12 илтгэл тавьж, асуултанд хариулж, харилцан ярилцав.

Илтгэл шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Шүрхүү, доктор Н.Ариунгуа, доктор Ч.Батцэцэг, доктор К.Дэмбэрэл нар багтаж, илтгэл тус бүрийг сэдэв сонголт, эрдэм шинжилгээний онол практикийн ач холбогдол, онол арга зүйн түвшин, шинэлэг санаа, эх сурвалж, мэдээлэл ашиглалт, боловсруулалт, бичлэг, илтгэх ур чадвар, асуултанд хариулсан байдал зэргийг харгалзан шалгаруулж доорхи байдлаар дүгнэсэн байна. Үүнд: 1-р байрыг эрдэм шинжилгээний ажилтан, магистр Р.Төрдалай “Хориод оны үеийн Монгол-Германы худалдаа, эдийн засгийн харилцаа (1925-1926 он)” илтгэл, 2-р байрыг эрдэм шинжилгээний ажилтан, магистрант Ш.Догмийчойдон “Үндэсний аюулгүй байдал ба шашны асуудал (Монгол Улсын жишээн дээр)” илтгэл, 3-р байрыг эрдэм шинжилгээний ажилтан, магистр Ц.Лхам “ХБНГУ-ын энх тайвныг сахин хамгаалах зарчим ба зэвсэгт хүчин, батлан хамгаалах асуудалд” илтгэл мөн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Ж.Орхон “Монгол, ОХУ-ын ураны салбар дахь хамтын ажиллагаа” илтгэл тус тус эзлэв.

Энэ хуралд оролцсон доктор (Sc.D) Ц.Баатар залуу ажилтнуудад хандаж үг хэлэв. Тэрбээр маргаашийн, ирээдүйн эрдэмтэн судлаач та бүхний илтгэлийг сонирхон сонслоо, залуусын хүрээлэнд ажилласан хугацаа харилцан адилгүй байгаа нь тэдний тавьсан илтгэлээс харагдаж байна. Та нарт захиж хэлэхэд онолын үзэл баримтлалын эх сурвалжийг сайтар ашиглах хэрэгтэй, хамгийн гол нь сэдэв сонголт, түүнийгээ хамгаалж чаддаг байх, эх баримт, сурвалжаар баталгаажуулах, судалгааны үндэслэлтэй байх ёстой гээд амжилт хүсэв.

Эрдэм шинжилгээний бага хурлыг цаашид уламжлал болгон жил бүр явуулах улмаар илтгэлүүдийг эмхэтгэн хэвлүүлж байх шийдвэрийг хурлыг зохион байгуулах комисс гаргав.